**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/183 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Баянзүрх цогцолбор
сургуулийн хөрөнгийн үнэд залруулга хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн гарсан 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/313 дугаар тушаалын хавсралтаар бүртгэсэн 15 нэрийн хөрөнгийн жагсаалтын 3-д заасан принтерийн нэг бүрийн үнийг 480,000 төгрөгөөр, 4-д заасан телевизорын нэг бүрийн үнийг 999,000 төгрөгөөр тус тус залруулахаар "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу холбогдох залруулга хийхийг Баянзүрх дүүргийн Баянзүрх цогцолбор сургууль /Ч.Чинчулуун/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн Баянзүрх цогцолбор сургууль /Ч.Чинчулуун/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/313 дугаар тушаалын хавсралт дахь жагсаалтын 3, 4-д заасан нэг бүрийн үнийг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын хрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмбөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

11505000501

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн
А/123 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Баянзүрх цогцолбор сургууль /төгрөгөөр/

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Үзүүлэлт | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх анхны | | Хандивлагч байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | нэр | Эх үүсвэр |
| 1 | Принтер | HP mfmp | 225 | 2018 | сайн | ш | 1 | 480,000.0 | 480,000.0 | Төгсөгчид | Хандив |
| 2 | Телевизор | Samsung | 32 inch TV | 2018 | сайн | ш | 3 | 999,000.0 | 2,997,000.0 | | |
| | **Тоног төхөөрөмжийн дүн** | | | | | | | | **3,477,000.0** | | |